



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/279

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 5 дугаар
сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 5,782,918.20 /Таван сая долоон зуун наян хоёр мянга есөн зуун арван найман төгрөг хорин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургууль /Н.Гэндэнсүрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 5,782,918.20 /Таван сая долоон зуун наян хоёр мянга есөн зуун арван найман төгрөг хорин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургууль /Н.Гэндэнсүрэн/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 07 сарын
 26 өдрийн 0/279 дугаар тушаалын хавсралт



Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Ном	4-7 жил	ш	4283		5,782,918.20	-	-	Эрүүл ахуйн шаардлага хангахгүй	актлах
Номын фондны дүн				4283		5,782,918.20	-	-		
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				4,283		5,782,918.20				
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө						5,782,918.20	-	-		
Татан төвлөрүүлэх хөрөнгө										
Худалдсанаас олох орлого										
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/										